

**ЭРХ ЧӨЛӨӨ, ХӨГЖИЛ ЦЭЦЭГЛЭЛТИЙН НУМ:
ЯПОН УЛСЫН ӨРГӨЖИН ХӨГЖИЖ БУЙ ДИПЛОМАТ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ ***

*Тора Асо**

Гурван жилийн дараа буюу 2009 оны 12-р сард Японы олон улсын харилцааны хүрээлэн (ЯОУХХ) үүсч байгуулагдсанахаа 50 жилийн ойтойгоо золгоно гэж дууллаа. Анх 1959 онд ЯОУХХ байгуулагдаж байхад миний бие их сургуулийн 1-р дамжаанд сурч байлаа. Тэр үед би оюутны жаргалаа эдлээд завгүй байсан болоод ч тэр үү, миний өвөө Шигэрү Ёошида юу байгуулах гэж нөр их хөдөлмөрлөж явсныг сайн мэдэхгүй явжээ. Хүүхэд ахуй насандаа долоо хоногийн сүүлч бүрээр Оисод уулздаг байсан миний мэдэх тэр хүн одоо юу хийж байгааг нь харин мэдэхгүй болчихсон байлаа.

Гэвч өнөөдөр та бүхний өмнө үг хэлж байгаа миний бие тухайн үед нөхцөл байдал ямар байсныг бүрэн ойлгож байна. Тиймээ, өвөө минь, та тэр үед ЯОУХХ байгуулж байсан. Өнөөдөр би та бүхэнд “Үнэт зүйлсэд тулгуурласан дипломат бодлого” болон “Эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум” гэсэн сэдвүүдээр ярих болно. Аль аль нь манай улсын гадаад бодлогын шинэ тэнхлэг бөгөөд шинэ нэр томьёо юм. Та бүхэн энэ танхимаас гарсныхаа дараа энэхүү хоёр үгийг санаж явна гэдэгт би гүнээ найдаж байна.

Япон-АНУ-ын холбоог бэхжүүлэх, БНХАУ, БНСУ, ОХУ зэрэг өөрийн хөрш орнуудтайгаа харилцаагаа эрчимжүүлэх нь Япон улсын гадаад бодлогын үндэс суурь юм. Мэдээж үүнийг одоо дахин давтаж хэлэх шаардлагагүй биз ээ. Энэ удаа миний хэлэх зүйл бол энэхүү бодлогод шинэ тэнхлэгийг нэмж бий болгох тухай юм. Нэгд, бид дипломат үйл ажиллагаагаа хөгжүүлэхэд ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль эрх зүйн засаглал, зах зээлийн эдийн засаг зэрэг “дэлхий нийтийн үнэт зүйлс”-д чухал ач холбогдол өгч

* Японы олон улсын харилцааны хүрээлэнгээс зохион байгуулсан семинар/2006.11.30/

* Гадаад хэргийн сайд

байгааг “Үнэт зүйлсэд тулгуурласан дипломат бодлого” гэж томъёолно. Хоёрдугаарт, Еврази тивийн гадар хавирган сараар ардчилал амжилттай цэцэглэн хөгжиж нэгэн нумыг бий болгож байна. Энэ бүс нутагт Япон улс “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум” бий болгохыг хүсч байгаа бөгөөд энэ нь гарцаагүй шаардлагатай байгаа гэж бодож байна.

Магадгүй зарим хүмүүс энэ үгийг сонсоод энэхүү барууны гэмээр маяг Японд зохихгүй гэж бодно биз. Дайны хүнд ялагдал амсан гадаад болон дотооддоо их хэмжээний хохирол учруулсан манай улс хэдийдээ “Үнэт зүйлсэд тулгуурласан дипломат бодлого” гэсэн гоё үг хэлж, бусдад номлол уншдаг болчихов гэж бодох ч хүн бас байгаа биз ээ. Гэвч миний бодлоор толинд тусах өөрийгөө хараад “хиймэл эсвэл дууриамал” гэж сэтгэх нь нэг төрлийн өвчин юм.

Та бүхэн энд сонссон бусад бүх зүйлийг мартаж болно. Харин “Япон улс энэхүү сэтгэлгээнээсээ салах цаг нэгэнт болсон, толинд буусан өөрийн тусгалдаа эргэлзэхээ больё” гэсэн санааг ой тойндоо шингээгээсэй гэж хүсч байна. Ер нь нас биед хүрсэн хүн дээрэнгүй, зусарч байж болохгүй бөгөөд урьд нь төсөөлж байсан ойлголтоо таягдан хаяж, нээлттэй сэтгэлгээгээр Япон орныг харвал урт удаан жил хуримтлагдсан түүхийн үйл явдалд үндэслэн оршин тогтнож буй улс юм гэдгээ ухаарах болно.

Олон жилийн туршлага, ололт амжилт, мөн алдаанууд нь ардчиллыг хөгжүүлж байдаг. Япон улсын ардчиллыг Мэйжигийн үеэс үүсэлтэй гэж бид ихэвчлэн ярьдаг. Гэвч “хууль эрх зүйн засаглал”, “гэрээг чандлан сахих” үзэл эрт дээр үеэс байсаар ирсэн. Япон улс дахь ардчиллын жинхэнэ түүхэн эхлэл нь бүр 1400-гаад жилийн өмнө байсан “17 зүйлт үндсэн хууль” уу, эсвэл 800 жилийн өмнөх Камакурагийн үед бий болсон “Жоей Шикимоку” хэмээх хууль уу гэдэг талаар халуухан маргалддаг.

Харин би Эдогийн үеийн иргэний нийгмийн цэцэглэлтийг энд онцлон тэмдэглэмээр байна. Жишээ нь: тэр үед ном зээлдэх бизнес эрхэлдэг байсан хүмүүс байдаг байлаа. Нэг ном зээлдэгч 100 гаруй үйлчлүүлэгчтэй байсан. Шинэ ном гарах болгонд ном зээлдэгч сагсандаа хийгээд үйлчлүүлэгчиддээ үзүүлэхээр авч явдаг. Нөгөө талаар үйлчлүүлэгчид нь “шинэ номоо тэсэн ядан хүлээж байлаа” гээд шинэ номтой хүүдийг задалдаг. Үүнээс үүдэн шинэ ном гарахыг “хүүдий задлах” гэж нэрлэдэг болсон юм. Орчин үеийн Япон хэлэнд энэ хэллэгийг “шинээр кино гарах” үед хэлдэг болсон билээ.

Номонд хэвлэгдэн гарсан сурталчилгаанаас бид уншигчдын тоо маш ихээр нэмэгдэж байсныг мэдэж болох юм. Суурин газрын иргэд хийгээд Самурай нар, бүр

тэдний эхнэр хүүхдүүд хүртэл ном уншдаг болсон байна. Энэ нь зөвхөн Эдо/одоогийн Токио хот/, Осака хотуудын эргэн тойрны газруудаар хязгаарлагдаж байгаагүй бөгөөд Японы өнцөг булан бүрийг ном зээлдэгчид хэрэн ном түгээж явдаг байжээ.

Эдогийн үед ард түмэн уран зохиолын номыг шимтэн уншдаг байсан болохоор орчин үеийн Японд манга түгэн дэлгэрэхэд гайхах хэрэггүй бизээ.

Ямар ч байсан, Эдогийн үеийн Япон “гайхамшигт” гэмээр энх тунх байдал ноёрхсон, нөхөрсөг нийгэмтэй байлаа. Хэрвээ тухайн үеийг одоогийн нэр томъёогоор тодорхойлбол тэр үеийн нийгэм харьцангуй “сайн засаглалтай” байлаа гэж хэлж болох байх. Ийм үндэс суурь байсан болохоор орчин үеийн төрийн байгуулалтын тогтолцоог Японд нэвтрүүлэхэд амжилт олсон гэж би хувьдаа үздэг.

Ардчилал, хүний эрх, эрх чөлөө, эрх зүйн засаглалын тухайд дэлхий ертөнц дээр төгс төгөлдөр болж хөгжсөн орон нэгхэн ч үгүй билээ. Ийнхүү түүхийг эргэн сөхөж үзвэл Япон улс тэдгээр нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэсэн анхдагч орны нэг биш үү гэсэн сэтгэгдэл төрдөг юм. Үүнд нэмж хэлэхэд дэлхийн 2-р дайны дараа Япон улс нь энх тайвныг эрхэмлэж, пацифизмыг дэлгэрүүлэх тал дээр ихээхэн амжилт олсон. Энэ дэлхий дээр сүүлийн 60 жилийн турш Японы өөрийгөө хамгаалах хүчин шиг ганц ч удаа их буу тавиагүй төдийгүй нэг ч буун дуу гаргаагүй зэвсэгт хүчин аль ч оронд үгүй билээ.

Сүүлийн үед Японы өөрийгөө хамгаалах хүчнийхэн Ирак болон бусад улс орнуудад энхийг сахиулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Үүний ачаар дүрэмт хувцас өмссөн Япон цэргийн дүр төрх эрс өөрчлөгдсөн гэж бодож байна. Тэдний урьдын “аймшигт” дүр төрх “найрсаг” төрхөөр солигдсон юм. Тэд “тухайн орон нутгийн иргэдтэй гар гараасаа барилцан нэгэн зүйлийн төлөө чармайдаг” болсон билээ.

Чухам ийм түүх, туршлага байгаа учраас Япон улс ардчилал, энх тайван, хүний эрх, эрх чөлөө зэрэг нийтлэг үнэт зүйлсийн талаар өөрийн үзэл санааг илэрхийлэхээс татгалзах шаардлагагүй гэж би үздэг. Ингээд Япон улс “Үнэт зүйлсэд тулгуурласан дипломат бодлого”-той эрхээ тунхаглаж, тогтоолоо мэдэгдэх болно.

Үүний дараа би та бүхний анхаарлыг Евроазийн орнуудад хандуулъя. Энэхүү бүслүүр нутаг нь дэлхийн 2-р дайны дараа баруун болон зүүний хоорондох хагарлын хөшигний улмаас маш ихээр өөрчлөгдсөн юм.

Энэ бүс нутгийг “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум” болгохыг хүсч үүнээс яриагаа эхэлье. Яагаад Африк эсвэл маш чухал бүс болох Латин Америк биш гэж та маргаж магадгүй. Жичдээ би энэ талаар тодорхой ярих болно. Харин Япон улс нь ЕХ

болон НАТО-тай цаашид хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг чармайл шалтгаан бий. Эндээс миний толгойд юу бууж байна вэ гэвэл дээр дурьдсан бүс нутгийн орнууд нуман хэлбэр бүхий нэгэн бүслүүр үүсгэх юм. Өрнө дорны хагарал эцэс болсны дараа тогтолцооны томоохон өөрчлөн байгуулалт хийж буй орнууд энэ бүс нутагт бий. Эдгээр улс орнуудыг холбон “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум” бий болгох хүсэлтэй байна.

Мэдээж Ойрхи дорнодын бүс нутаг ч мөн энэ бүслүүрт багтдаг ба Ойрхи дорнодын талаарх бодлогын тухайд тусдаа илтгэл тавих шаардлагатай тул энэ удаа дэлгэрэнгүй ярихаа байя.

Үнэндээ одоо миний толгойд Камбож, Лаос, Вьетнам буюу эдгээр орнуудын нэрний эхний үсгээс бүтсэн КЛВ гэж нэрлэдэг нэгэн бүс нутаг бодогдож байна. Мөн түүнчлэн дэлхийг байгалийн нөөцөөр хангахад нэн чухал үүрэг гүйцэтгэдэг Төв Азийн орнууд болох Гүрж, Азербайжан зэрэг Кавказын бүс нутгийн орнууд байна. Цаашилбал, өнгөрсөн зун миний айлчилсан Украйныг нэрлэж болох ба нийслэл Киев болон бусад гол хотууд нь дэлхийн гүрнүүдийн хотуудтай нэгэн агаараар амьсгалж байгааг миний бие мэдэрсэн билээ.

Япон улс эдгээр улс орнуудтай гадаад хэргийн сайд нарын уулзалт хийх зэрэг замаар байнгын харилцаа холбоотой байхыг эрмэлздэг юм. Энэ мэтчилэн хүчин чармайлт гаргаснаа эдгээр улс орнуудын нөхцөл байдлыг ойлгоход илүү дөхөм болох юм.

Товчхон хэлбэл, өдгөө олон орон “эдийн засгийн хөгжил цэцэглэлт, ардчиллаар дамжин, энх тайван, аз жаргалаа олох замаар” замнаад байна. Энэ нь дайны дараа Япон улсын туулж өнгөрүүлсэн, мөн өнөөгийн АСЕАН-ны орнуудын туулж буй замтай яв цав нийцэж байгаа юм. Гэвч ардчилал нь эцэс төгсгөлгүй марафон гүйлт бөгөөд түгээмэл ойлголтоор бол эхний тав орчим километр нь хамгийн хэцүү байдаг юм. Чухамхүү энэ үе шатандаа залуу ардчилсан орнууд “Өсөлтийн гормон” хэмээн нэрлэж болох зүйлийг үлэмж хэмжээгээр ялгаруулдаг ба энэ нь нийгмийг тогтворжуулах тогтолцоог буй болгоход чиглүүлж болдог. Харин заримдаа эхэн үедээ эвдрэл сүйрлийн импульс нь давамгайлах явдал гардаг.

Энэ бол бусдын тухай ярьж байгаа хэрэг биш юм. Жилийн өмнө Азийн дипломат үйл ажиллагааны асуудлаар тавьсан илтгэлдээ хэлж байсанчлан Япон улс дайны өмнө ба дараа тогтворгүй үйл явдал, эрс тэс өөрчлөгдөх цаг үеийг олонтаа туулж өнөөгийн тогтвортой, амар тайван байдлаа олж авсан юм.

Иймээс би Япон улсын гадаад хэргийн сайдын хувьд дараах зүйлсийг амлаж байна. Манай улс цаашид, Зүүн хойд Азиас Төв Ази, Кавказ, Турк, Төв болон Зүүн Европ, Балтийн улс орнуудыг багтаасан “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-анд эцэс төгсгөлгүй марафонд гүйж эхэлсэн эдгээр ардчилсан улс орнуудтай хамт гүйх болно.

Энэхүү нум хэлбэр үүсгэх өргөн уудам бүс нутагт эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засаг болон хууль эрх зүйн засаглал, хүний эрхийг дээдэлдэг улс орнууд намхан шүрэн арал цаг хугацаа өнгөрөхийн хэрээр том арал болон хувирч, улмаар уул нуруу болдог шиг аажим аажмаар хөгжин тэлэх биз ээ.

Япон улс эдгээр улс орнууд урагш тэмүүлсэн алхам хийхэд туслан дэлхий дахины дэг журмыг тайван, энх амгалан байлгахыг зорьдог.

Манай улс, амин чухал ашиг сонирхол нь дэлхийн тогтолцооны тогтвортой байдалд шуудхан нөлөөлдөг том гүрнүүдийн нэг юм. Тиймээс хэрэв Япон улс үндэсний эрх ашгийн хүрээнд өөрийн оршин тогтнол, тогтвортой байдал болон хөгжил цэцэглэлт гэсэн үндсэн 3 зорилт баримтлая гэвэл Япон мэт том гүрэн дэлхий дээр өрнөж буй аливаа үйл явдлыг өөрт хамааралгүй буюу сонирхолгүй хэмээн үл тоомсорлож болохгүй.

Тиймээс Япон улс ижил төстэй байр суурь, ашиг сонирхол бүхий АНУ, Австрали, Энэтхэг, ЕХ болон НАТО-гийн гишүүн орнууд зэрэг найрсаг улс гүрнүүдтэй холбоогоо улам бүр бэхжүүлэхийн зэрэгцээ хамтдаа “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-ыг бий болгож өргөжүүлэхийн төлөө ажиллах ёстой гэдэгт миний бие бат итгэлтэй байна.

Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд Япон, Энэтхэг 2 улсын харилцаа, жишээлбэл Япон-Хятадын харилцаатай харьцуулахад ихээхэн сул байгааг мэдэж болно. Зорчиж буй хүний тоог авч үзвэл Япон-Хятадын хооронд жилд 4.17 сая хүн зорчдог бол Япон-Энэтхэгийн хувьд энэ тоо ердөө 150 мянга байна. Жил бүр Хятадын 80 орчим мянган оюутан Японд суралцдаг бол Энэтхэг оюутны тоо 400 гаруйхан байна. Япон-Хятадын хоорондын шууд нислэгийн тоо долоо хоногт 676 байхад, Япон-Энэтхэгийн хооронд хийж буй шууд нислэгийн тоо долоо хоногт ердөө 11 байна. Иймд бид ойрын хэдэн жилийн дотор байдлыг эрс сайжруулахад чиглэсэн алхам хийх ёстой гэж бодож байна. “Эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-ыг бий болгоно гэдэг нь ямар учиртай болохыг та бүхэн ойлгосон болов уу. Иймээс бид чухам юу хийх вэ гэсэн асуулт гарч ирэх нь мэдээж.

Үнэндээ Япон улс өөрийн байр суурийг баталгаажуулах ямар нэгэн ололт амжилтгүйгээр хий хоосон жүжиглэж байна гэж ойлгож болохгүй. Арван жилийн өмнө буюу 1996 оны Лионы дээд хэмжээний уулзалтын үеэр Япон улс Ардчилсан Хөгжлийн

Түншлэл буюу товчилбол АХТ-ийг тунхаглан зарласан бөгөөд энэ нэрийг тухайн үеийн Гадаад хэргийн яам өгч байлаа. Энэ нь залуу ардчилсан оронд засаглалын механизмыг буй болгоход туслах арга байсан билээ.

Энэ ажлын хүрээнд ардчилал, зах зээлийн эдийн засаг өөд тэмүүлэх үеийн зовлон зүдгүүрийг амсаж байсан Камбож, Лаос, Вьетнамын (КЛВ)-ын орнууд болон Монгол, Узбекистан зэрэг орнуудад хууль эрх зүй, шүүхийн тогтолцоо гэсэн улсаа бүтээн байгуулах үндсэн ажилд гол анхаарлаа төвлөрүүлэн тусалж бодит үр дүнд хүрч байсан. Гэхдээ энэ бол АХТ-ийн зөвхөн нэг хэсэг төдий зүйл юм. Хэрэв та үүний учир утгын талаар мэдэхгүй бол энэ нь бид өөрсдийн мэдээллийг гадагш нь хир тааруухан хүргэдгийг харуулж байгаа хэрэг бизээ.

Өөрсдийн мэдээллийг гадагш нь тааруухан хүргэж буйтай холбогдуулж нэгэн зүйлийн талаар дурдахыг минь зөвшөөрнө үү. Хүйтэн дайны сүүлийн жилүүдэд Япон улс Зүүн Европын орнуудад үлэмж хэмжээний тусламжийг үзүүлсэн тухай ярихыг хүсч байна.

1989 оны зун Берлины хана хараахан нураагүй байхад энэ тухай таамаглан өдрөөс өдөрт хүчээ авч байлаа. Энэ үед Японы засгийн газар Лионы дээд хэмжээний уулзалтын үеэр олдсон боломжоо ашиглан Польш болон Унгарт томоохон хэмжээний санхүүгийн тусламж үзүүлэхэд бэлэн байгаагаа мэдэгдэж анхны алхмаа хийсэн.

Дараа жилийн нэгдүгээр сард дөнгөж ханаа нураагаад байсан Берлинд тухайн үеийн ерөнхий сайд Тошики Кайфу зочлохдоо Польш болон Унгарт нийт 1,95 тэрбум доллар буюу 280 тэрбум иенээс давсан асар их хэмжээний санхүүгийн тусламж үзүүлэхээ мэдэгдэж амалсандаа хүрдгээ харуулсан билээ.

Босни Герцоговинд ч мөн адил 1995 оны зөрчилдөөн зогссон даруйд Япон улс 500 сая ам. долларын санхүүгийн тусламж олгосон. Энэ хандив АНУ-ын дараа хоёрдугаарт орох хэмжээний тусламж үзүүлсэн гэж одоо хэлэлцдэг бололтой. Тухайн үед “Япон улс яагаад тэгтлээ тусламж үзүүлж байгаа вэ” гэсэн сэтгэгдлийг төрүүлж байсан хэдий ч одоо Япон улс л хамгийн үр өгөөжтэй туслалцаа дэмжлэг үзүүлсэн хэмээн хэлүүлдэг болсон бололтой юм.

Хэрэв үүнийг “Үнэт зүйлст тулгуурласан дипломат бодлого” гэхгүй юм бол өөр юу байсныг надад хэлж өгөөч. Бид “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-ыг байгуулах хүсэл санаагаа аль эрт энэ үйлдлээр илэрхийлж байсан болов уу?

Япон улсын Азид хийж бүтээсэн зүйлс үнэндээ онцгойлон тэмдэглүүштэй гэдгийг хэлмээр байна. 1997-1998 онд Өмнөд Солонгос болон АСЕАН-ы орнууд бүгд нэгэн зэрэг валютын хямралд орсон билээ. Тухайн үед Япон улс дефляцийн хямралын хамгийн хүнд үеийг туулж байлаа. Гэсэн хэдий ч 1998 оны 10-р сард Япон дээрх улс орнуудад нийт 30 тэрбум ам. доллар буюу 4 триллион иенээс давах санхүүгийн тусламж үзүүлсэн бөгөөд Өмнөд Солонгост ойролцоогоор 8,4 тэрбум, Индонезид 3 тэрбум долларыг олгожээ. Тэр цаг үеэс хойш ойролцоогоор 10 жил өнгөрсөн бөгөөд Өмнөд Солонгос, АСЕАН-ы аль аль нь “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум” марафон гүйлтийн аварга болоод байгааг бид харж байна. Өөрөөр хэлбэл, өнөөдөр миний яриад буй дипломат бодлогын тэнхлэг нь Японы хувьд ямар нэгэн шинэ зүйл биш юм. Сүүлийн 16-17 жилүүдэд Японы гадаад бодлого бага багаар хуримтлуулсан ололт амжилтандаа нэр өгөх, байр байдлаа тодорхойлохоос хэтэрсэнгүй. Гэсэн хэдий ч байр байдлаа тодорхойлохгүй бол хийж байгаа зүйлийнхээ учир утгыг олохгүй. Бодлогодоо нэр оноож өгөхгүй бол гадаад болон манай орны ард иргэд амархан мартаж орхино. Иймээс үг чухал юм. Үүнийг ухамсарлан тодорхой нэр оноохыг “шинэ тэнхлэг” гэж хэлж болох юм.

“Япон КЛВ-ийн дээд хэмжээний уулзалт” болон тус улсуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалт, “Төв Ази +Япон” хэлэлцээр, Төв Европын улсууд болох Чех, Унгар, Польш, Словакаас бүрдэх Вишеград 4 буюу В4 бүлгийнхэнтэй хийх яриа хэлэлцээр гэх зэрэг яриа хэлэлцээрийг манай улс хийж ирлээ.

Японы хувьд эдгээр бүлгүүдтэй санал солилцохыг тогтмолжуулахын зэрэгцээ одоо нэн чухалд үзэж, тогтмол явуулж буй уулзалтыг улам боловсронгуй болгон, холбогдох улс орнуудтай байнга уулзаж санал солилцож байх шаардлагатай байна. Хоёр талын түвшинд энэхүү үйл ажиллагааг Афганистантай аль хэдийн эхлүүлээд байгаа юм.

Ийм үед эдгээр холбоог тогтоох хамгийн ухаалаг арга бол Япон улсын тулгуур үүргийг гүн гүнзгий ойлгодог орнуудыг түших явдал юм. Тухайлбал Ойрхи Дорнод болон Төв Азийн тухай арвин их мэдлэгтэй Турк, мөн Украйныг ойлгоход ихэд түлхэц болдог Польш зэрэг улсууд миний санаанд зурсхийн орж байна.

Би Польшид гадаад хэргийн сайдын хувиар очиж байгаагүй ч 2003 оны 8 сард айлчлал хийсэн Ерөнхий сайд асан Жүничиро Коизүмиг гайхашруулсан зүйл зөвхөн Шопен биш байв. “Үнс ба алмас эрдэнэ” зэрэг киногоороо дэлхийд нэрд гарсан найруулагч Андрей Важда Кёосера Корпорацийн Др.Казүо Инаморигоос гардан авсан Кёотогийн шагналынхаа мөнгөөр өөрийн төрөлх хот буюу эртний нийслэл Краковд

“Японы урлаг, технологийн манга төв” барьсан. “Хокусай манга”-ийн нэрээр нэрлэгдсэн энэхүү төвд залуу Важдагаар “сэтгэл хөдөлсөн” гэж хэлүүлсэн нэгэн цуглуулагчийн цуглуулсан зарим модон барын бүтээлүүд тавигдсан байдаг.

Орчин үеийн Япон манга өнөөдөр Польшид хэрхэн тархан түгсэн нь мөн гайхмаар бөгөөд миний хувийн цуглуулгад Польшийн Гадаад хэргийн сайдын бэлэглэсэн “Ину Яша” бүтээлийн польш хэлний хувилбар хүндтэй байр суурийг эзэлдэг. Өдгөө Польшид “Япон” гэсэн нэртэй Польш-Японы Мэдээлэл технологийн дээд сургууль байдаг. Тус дээд сургууль НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Японоос нийт 350,000 ам долларын санхүүгийн тусламж авч, “Мэдээллийн технологийг Украйнд нэвтрүүлэх нь” төслийг санхүүжүүлдэг юм. Орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан зайны сургалтын тогтолцоог бий болгохоор туршиж байна.

Өөрөөр хэлбэл бид Японы тухай гүн гүнзгий ойлголттой, түүнчлэн газар зүйн болон соёлын хувь “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-нд багтаж байгаа өсөн хөгжиж буй улс орнуудад үр дүнтэй тус хүргэх чадвартай улс орнуудтай харилцан хамтын ажиллагааг өрнүүлэхийг хичээж байна. Тухайлбал, Польш энэхүү байр суурьтай улс орнуудын нэг бөгөөд Польштой хамтран ажиллах нь үлэмж үр нөлөөтэй юм.

Хуучнаар социалист гэгдэж байсан улс орнууд буюу Польш, Унгар, Балтийн гурван улс 2004 оны 5-р сард ЕХ-нд элсэн орсноор тусламж авдаг байснаа тусламж үзүүлдэг улс орон болон огцом өөрчлөгдсөн юм. Балтийн тэнгис хүртэл үргэлжлэх “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-ын бүсэд багтааж байгаа ялгавартай байдлыг ихэсгэхгүйн тулд “ГУАМ”-ын улсууд буюу Гүрж, Узрайн, Азербайжан, Молдовт тогтвортой байдал тогтоох шаардлагатай юм.

Дээрхийг харгалзаж бий болсон гэж бодогдмоор нэг жишээ дурьдахад, жилийн өмнө Украйн, Гүрж, Литв, Румын улсууд хамтран Ардчилсан Сонголттой Нийгэмлэг /АСН/ байгуулсан. Тус бүлгийн гол зорилго нь Балтийн тэнгисээс Хар тэнгис болон Каспийн тэнгис орчмын бүс нутаг буюу бидний “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум” гэж зөгнөн харж байгаа бүс нутагт ардчиллын хүчирхэг үндсийг тавихад оршиж байгаа.

Бид АСН, ГУАМ-ын улс орнуудтай аль болох өргөн хэмжээнд харилцах хүсэлтэй байна. Дахин хэлэхэд, энэ тохиолдолд Японтой түншлэх бололцоотой улс орнуудтай өргөнөөр хамтран ажиллах шаардлагатай гэж бодож байна. Үүнтэй уялдуулан Японы дипломат үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд Японы дипломат төлөөлөгчдийн газрын болон дипломат ажилтнуудын тоог үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Дээр дурдсанчлан, ГУАМ-ын болон зарим бүс нутгийн улс орнуудад явуулж буй Японы дипломат үйл ажиллагаа тийм ч хангалттай бус байгаа бөгөөд үүнийг даруй бүрдүүлэх шаардлагатай байна.

Ингээд эцэст нь зарим зүйлийг та бүхний оюун ухаанд тунгаан бодуулахаар үлдээлээ. Бид Английн яруу найрагч Киплингтийн хэлсэн “Дорно бол дорно, өрнө бол өрнө, энэ хоёр хэзээ ч нийлэхгүй” гэдэг үгийг дагавал өрнө дорно хоёр огт уулзалдахгүй гэж хэлэх нь бий. Хэдий тийм ч миний бие өнгөрсөн 5-р сард Бельгийн Бруссельд байрлах НАТО-гийн төв байранд айлчлах үеэр нухацтай илтгэл тавьсан.

Японы өөрийгөө хамгаалах хүчин хийгээд НАТО-ийн дэлхийн энх тайвныг байгуулах, элдэв мөргөлдөөнөөс сэргийлэх салбар дахь цаашид хамтын ажиллагаа өргөжих магадлал өндөр, үүнтэй холбогдуулан бид одооноос эхлээд нягт харилцаатай байя гэсэн санал тавьсан. Түүнчлэн дорноос өрнө рүү, өрнөөс дорно руу далавчаа дэлгэн Энэтхэгийн далайгаас Афганистан хүртэл Япон, НАТО хоёр мөр зэрэгцэн хүчин чармайлтаа гаргаж ажиллах нь хэдийчинээ хачирхалтай хэрэг байхаа больжээ.

Өнөөдөр би үнэт зүйлсэд тулгуурласан Японы дипломат үйл ажиллагаа Евроази тивийн гадар хавирган сараар “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум” бүтээн байгуулах хүслээ ярилаа. Япон нь эрх чөлөө, ардчилал, хүний эрхийг дээдлэх, хууль эрх зүйн засаглалыг чанд сахидгаараа бусдаасаа дутуугүй байдаг. 21-р зууны эхний хагаст хүчээ зориулах чухал ач холбогдолтой асуудлыг Япон улстай бодол санаа нэг орнуудтай хамтран авч хэлэлцэхэд баяртай байх болно. АНУ, Австрали, Энэтхэг, ЕХ, НАТО-ийн гишүүн орнуудын оролцоогүйгээр хийгдэхгүй нь ойлгомжтой.

Магадгүй та бүхэн энэ Таро Асо хий мөрөөдөж байна гэж бодож болох авч эцэст нь хоёр санаа хэлэхийг хүсч байна. Зөн хараа нь голдуу хоосон мөрөөдөл байдаг. Харин Японы дипломат бодлогод зөн хараа хэрэгтэй. Үүний учир шалтгаан нь миний хэлэх сүүлийн санаанд байгаа Японы дипломат бодлогын алсын хараа нь бүх япончуудын алсын хараа юм. Япон хүн бүр хүндэлж бахархах тэр л алсын харааг хэлж байна.

Дипломат бодлого гэдэг нь ард иргэддээ үндэслэл сайтай, бодит, амар тайван өөртөө итгэх итгэлийг бий болгох ажил юм. Гадаад хэргийн сайдын хувиар Японы ард түмэнд бат итгэл, урам зоригтой байдлыг авчрахыг хүсч үүнд хүрэх арга замыг үргэлжлүүлэн хайж байна. Үүний тулд олон үг хэлэх болно. Ингээд би үүгээр өнөөдрийн яриагаа өндөрлөе.

Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Ясүёши Ичихаши

(МУИС-ийн ОУХС дээр уншсан лекц)

2006.10.31



Японы гадаад бодлого ба Япон Монголын Харилцаа

» Дайны дараах Японы гадаад харилцааны түүхэн замнал

- Гадаад бодлогын үндэс суурь
- Голлох орнуудтай харилцах харилцаа
- Япон Монголын харилцаа

Дайны дараахи Японы гадаад харилцааны түүхэн замнал

1945.8.6
Хирошима

1945.8.9
Нагасаки

Атомын бөмбөгдөлт

Дайны дараахи Японы гадаад харилцааны түүхэн замнал

Бууж өгөх тухай "Пололам"-ийн тухалгаллыг хүлээн зөвшөөрсөн 1945.8.15

Холбоотны цэргийн эзлэлт (АНУ-ын цэргийн удирдлага доор) 1947.5.3 хүчин төгөлдөр болсон

Япон Улсын үндсэн хууль батлагддаг нийтэд зарласан 1946.11.3

Санфранцискогийн Энх тайвны гэрээ 1951.9

Япон АНУ-ын Аюулгүй Байдлын Гэрээ 1952.2 (1960 онд шинэчлэгдсэн)

НҮБ-д гишүүнээр элссэн 1956.12

Дайны дараахи Японы гадаад харилцааны түүхэн замнал

Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрт (GATT) нэгдэн орсон 1964

Япон ЗХУ-ын дипломат харилцаа сэргэсэн 1956

Япон БНСУ-ын дипломат харилцаа сэргэсэн Япон БНСУ-ын Гэрээ 1965

Япон БНХАУ-ын дипломат харилцаа сэргэсэн 1972

Гадаад бодлогын үндэс суурь

- Энх тайванч улсын замаар замнах
- Аюулгүй байдлаа хангах
- Энх тайвны замаар олон улсын тавцанд хувь нэмрээ оруулах

Дахин милитаризмийн замаар замнахгүй байх

Үндсэн хуулийн 9 зүйлд зааснаар "зөвхөн өөрийгөө хамгаалах"
Япон АНУ-ын Аюулгүй Байдлын Гэрээний дагуу гаднаас ирэх аюулыг тогтоон барих

Дайны дараах нөхөн төлбөр зэрэг→Хөгжлийн Албан Ёсны Тусламж (ХАЕТ)

"Терроризмтэй тэмцэх тусгай хууль", "Иракийн тухай тусгай хууль"

"Цөмийн зэвсэг"-ийн талаар баримтлах бодлого

- Цөмийн зэвсэггүй байх 3 зарчим
 - үйлдвэрлэхгүй байх
 - эзэмшихгүй байх
 - гаднаас оруулахгүй байх
- Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээ (NPT)
- Зэвсгийн экспортыг хориглох
- Дотоодын хуулийн дагуу атомын энергийг зөвхөн энх тайвны зорилгоор ашиглах

(АНУ-д технологи экспортлохоос бусад)

Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл

- 9 дүгээр зүйл. Японы ард түмэн шуудрага ёс, дэг журмыг үндэс болгосон дэлхий дахины энх тайвныг чин сэтгэлээсээ хүсч, тусгаар улсынхаа эрхийн хүрээнд дайн хийх, цэргийн хүчээр айлган сүрдүүлэх, цэргийн хүч хэрэглэх арга замаар олон улсын маргаантай асуудлыг шийдвэрлэхээс үүрд татгалзах.
- 2 Дээрхи зорилтыг биелүүлэхийн тулд хуурай замын, далайн, агаарын болон бусад аливаа цэргийн хүчингүй байх. Аливаа улстай дайн хийх эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх.

Голлох орнуудтай харилцах харилцаа (1) АНУ

- Японы хувьд хамгийн чухал түнш
- Аюулгүй байдал – Япон АНУ-ын Аюулгүй Байдлын Гэрээ
- Эдийн засаг – Нэг номерийн худалдааны түнш орон

< Экспорт >

< Импорт > (нэгж: 1000 ам.доллар, %)

Байр	Улсын нэр	Мөнгөний дүн	Хувь	Байр	Улсын нэр	Мөнгөний дүн	Хувь
	Экспортын нийт дүн	565,038,784	100.0		Импортын нийт дүн	454,668,993	100.0
1	АНУ	126,838,842	22.5	1	БНХАУ	94,227,211	20.7
2	БНХАУ	73,818,019	13.1	2	АНУ	62,434,936	13.7
3	БНСУ	44,200,401	7.8	3	БНСУ	22,026,854	4.8
4	Тайвань	41,958,830	7.4	4	Австрали	19,429,633	4.3
5	Хонг Конг	35,373,609	6.3	5	Индонези	18,670,068	4.1

(JETRO Вэб хуудас, ХХО ОУ-ын Төлбөрийн Баланс "Японы худалдааны түнш топ 50 орон", 2004)

Япон АНУ-ын Аюулгүй Байдлын Гэрээ

Хүйтэн дайны үе

Баруун, зүүнийхний сэргөлдөөний үед Японы хамгийн наад захын өөрийгөө хамгаалах хүч дээр гаднаас ирэх аюулыг тогтоон барих хүчийг (сөрөн зогсох хүч) нэмсэн.

Япон улс өөрийн зэвсэгт хүчинг (аюулыг тогтоон барих хүч) бий болгох шаардлагагүй байсан. Дайны дараахи эдийн засгаа сэргээхэд бүхий л хүчээ дайчилж чадсан.

Япон АНУ-ын Аюулгүй Байдлын Гэрээ

Хүйтэн дайны дараах үе

Эрх чөлөө, ардчилсан ёсыг дээдэлсэн эвсэл Гэрээ байгаа явдал нь бүс нутгийн энх тайван тогтвортой байдалд хувь нэмэр болдог


→ "Япон АНУ-ын батлан хамгаалах хамтын ажиллагааны чиг шугам" 1997

→ 9.11-ны үйл явдлаас хойших шинэ хандлага "Терроризмтэй тэмцэх тусгай хууль" (2001), "Иракийн тухай тусгай хууль" (2003)



Япон АНУ-ын Аюулгүй Байдлын Гэрээ

Япон дахь АНУ-ын цэргийн баазууд



Голлох орнуудтай харилцах харилцаа (2) БНХАУ

1972 Дипломат харилцаа сэргэсэн
Япон БНХАУ-ын хамтарсан мэдэгдэл
("Албан ёсны ганц засгийн газар"
"Тайвань бол БНХАУ-ын нэг хэсэг" байр суурийг ойлгон хүндэтгэх)
1978 Энх тайван найрамдлын гэрээ
1979 Өөрчлөн байгуулалт, нээлттэй бодлого
эхэлсэн БНХАУ-д ХАЁТ үзүүлж эхэлсэн

1980-аад он Түүхийг ойлгохтой холбогдсон асуудал (сурах бичгийн агуулга, Ясукуни
1990-ээд он БНХАУ-ын эдийн засгийн хөгжил сүмийн асуудал) гарч ирсэн.
Япон БНХАУ хоорондын эдийн засгийн харилцааны хөгжил
Хоёр дахь худалдааны түнш

< Экспорт >

< Импорт > (нэгж : 1000 ам.доллар, %)


Байр	Улсын нэр	Мөнгөний дүн	Хувь	Байр	Улсын нэр	Мөнгөний дүн	Хувь
	Экспортын нийт дүн	565,038,784	100.0		Импортын нийт дүн	454,668,993	100.0
1	АНУ	126,838,842	22.5	1	БНХАУ	94,227,211	20.7
2	БНХАУ	73,818,019	13.1	2	АНУ	62,434,936	13.7
3	БНСУ	44,200,401	7.8	3	БНСУ	22,026,854	4.8

Түүхийн асуудал дахин сөхөгдсөн, "улс төрийн харилцаа хөрч, ЭЗ-гийн харилцаа оргилсон"

(JETRO Вэб хуудас, ХХО ОУ-ын Төлбөрийн Баланс "Японы худалдааны түнш топ 50 орон", 2004)

Голлох орнуудтай харилцах харилцаа (3) ОХУ

1956 Япон ОХУ-ын хамтарсан тунхаглал, дипломат харилцаа сэргэсэн
• Энх тайвны гэрээ байгуулагдаагүй
• Нутаг дэвсгэрийн асуудал шийдэгдээгүй



ЗХУ задарсны дараа (90-ээд оны үеийн үйл явдал)
Эдийн засгийн харилцаа өргөжсөн
Энх тайвны төлөөх хамтын ажиллагаа өргөжсөн

1993 Ерөнхийлөгч Елциний Японд хийсэн айлчлал "Токиогийн тунхаглал"
"Нутаг дэвсгэрийн маргааныг шийдвэрлэж байгуулах" зорилт энх тайвны гэрээ
1997 Ер. Сайд Хашимотогийн ОХУ-д хийсэн айлчлал
1998 Ер. Сайд Обучигийн ОХУ-д хийсэн айлчлал
2000 Ерөнхийлөгч Путиний Японд хийсэн айлчлал
2001 Ер. Сайд Мориогийн ОХУ-д хийсэн айлчлал
2003 Ер. Сайд Койзүмигийн ОХУ-д хийсэн айлчлал

Хичээл зүтгэл үргэлжилсээр

Голлох орнуудтай харилцах харилцаа (4) БНСУ

1910 Солонгос Японд нэгдсэн
1945 Солонгос улс тусгаар тогтносон
1951 Өмнөд хойт солонгосын дайн
1965 Япон БНСУ-ын гэрээ, дипломат харилцаа сэргэсэн

- БНСУ-ын эдийн засгийн хөгжил Японы Э/З-гийн хамтын ажиллагаа, Э/З-гийн харилцаа ихээхэн өргөжсөн
- Хөл бөмбөгийн ДАШТ-ийг хамтран зохион байгуулсан, залуучуудын соёлын харилцаа
- Түүхийг ойлгохтой холбогдсон асуудал

Голлох орнуудтай харилцах харилцаа (4) Хойт Солонгос

Цөмийн зэвсэг - Пуужингийн асуудал
Зургаан талт хэлэлцээ
Япон иргэдийг хулгайлсан асуудал
Дипломат харилцааг сэргээхтэй холбогдсон яриа хэлэлцээ

Голлох орнуудтай харилцах харилцаа (5) ЗӨА-АСЕАН

Дайны нөхөн төлбөр зэрэг → Э/З-ийн бодит тусламж

АСЕАН-ийн орнуудын Э/З-гийн хөгжил
- Аюулгүй байдалтай салшгүй холбогдсон уян хатан гадаад бодлого

Япон улсад баялаг нийлүүлэгч
Том зах зээл (544 сая 360 мянган хүн амтай)
Ач холбогдол : газрын тос зэргийн далайн тээврийн зам

(World Bank, World Development Indicators database)

Бүс нутгийн хамтын ажиллагааны хөгжил

АСЕАН + 3


АСЕАНЫ БҮСИЙН ЧУУЛГА

АЗИ ЕВРОПИЙН НИЙГЭМЛЭГ

ЗҮҮН АЗИЙН ХАМТЫН НИЙГЭМЛЭГ

Голлох орнуудтай харилцах харилцаа (5) Ойрх дорнод

Газрын тос нийлүүлэгч




Ойрх дорнодын тогтворгүй байдал - Анхаарлын төвд байдаг асуудал

(Газрын тосны Лиг "өнөөгийн газрын тос үйлдвэрлэлийн мэдээ (2005.4)")

Японы Олон Улсын тавцан дахь хувь нэмэр ~ Энх тайван ба тогтвортой хөгжлийн төлөө ~


НҮБ-ын төсөвт - 279 тэрбум 600 сая йен (2004)

Энхийг сахиулах үйл ажиллагаа
Зэвсэг хорогдуулах
НҮБ-ын шинэчлэл
Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэл



("Japan 2005 An International Comparison", Keizai Koho Center, Dec. 2004.)

- ХАЕТ нийт дүн 8 тэрбум 859 сая доллар (2004 оны урьдчилсан гүйцэтгэл)
- Байгаль орчин Киотогийн протокол, глобал дулаарал



(график : ГХЯ-ны вэб хуудасны "Гол донор орнуудын ХАЕТ"-аас авав)
<http://www.mofa.go.jp/mofaj/gaiko/oda/shiryo/jisseki.html>

Япон ба Монгол

- Хоёр талт хэлэлцээр, протокол

Дипломат харилцаа тогтоосон (1972.2.24)

Соёлын харилцааны протокол (1974)

Э/З-ийн ХА-ны хэлэлцээр (1977) Ноолуурын үйлдвэр

Худалдааны хэлэлцээр (1990.3.1)

Хилийн чанад дахь сайн дурынхныг хүлээн авах

тухай хэлэлцээр (1991.3.26)

Агаарын харилцааны хэлэлцээр (1993.11.25)

Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай хэлэлцээр (2001.2.15)

Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр

(2003.12.4-нд гарын үсэг)

Дээд албаны хүмүүсийн харилцан айлчлал

1989.5 ГХ Сайд Үно
 1991.8 Ер. Сайд Кайфу, ГХ Сайд Накаяма
 1992.5 Зөвлөхүүдийн танхим (ЗТ) дарга Накада
 1993.8 ЗТ-ын АЕ айлчлал (ЯМБ дарга Сайто, бусад)
 1997.7 ТТ-ын АЕ айлчлал (Дэд дарга Ватанабэ, г.м)
 1997.8 Нийгмийн Хамгааллын Сайд Койзүми
 1999.7 Ер. Сайд Обүчи, ДХ Сайд Нода, ГХ Сайд Такамура, ЗГХЭГ дэд дарга Сүзүки, ШХ Сайд Нода
 1999.8 ЗТ-ын АЕ айлчлал (ЯМБ дарга Нозава, бусад)
 2002.6 Акишинономия Хан хүү гэргийн хамт
 2003.9 ГХ Дэд Сайд Яно
 2004.8 ГХ Сайд Кавагүчи
 2004.9 ЗТ-ын АЕ айлчлал (ЯМБ дарга Озүчи, бусад)
 2005.6 ГХ Дэд Сайд Танигава

1990. Сайд нарын зөвлөлийн дарга Содном
 1990.11 Ерөнхийлөгч Очирбат (Эзэн хаанд өргөмжлөгдөх ЁА)
 1993.9 Ер. Сайдын 1-р орлогч Пүрэвдорж (Донорын Уулзалт)
 1993.11 Ер. Сайд Жасрай
 1994.10 УИХ-ын дарга Багабанди
 1995.1 Ер. Сайдын 1-р орлогч Пүрэвдорж (газар хөдлөлт)
 1995.11 ГХ Сайд Гомбосүрэн
 1997.2 Ер. Сайд Энхсайхан
 1998.5 Ерөнхийлөгч Багабанди
 1999.3 УИХ-ын дарга Гончигдорж
 1999.5 ГХ Сайд Туяа
 2000.9 ГХ Сайд Эрдэнэчулуун
 2001.2 Ер. Сайд Энхбаяр
 2002.2 УИХ-ын дарга Төмөрчир
 2002.7 ГХ Сайд Эрдэнэчулуун
 2003.11 Ер. Сайд Энхбаяр (Донорын Уулзалт)
 2003.12 Ерөнхийлөгч Багабанди
 2005.3 ГХ Сайд Мөнхоргил

Иж Бүрэн Түншлэл

- 1997 Хоёр З/Г-ын Хамтарсан Мэдэгдэл (Ер. Сайд Хашимото, Ер. Сайд Энхсайхан)
 "Монгол Улс, Япон Улсын Засгийн газрууд хоёр орны хооронд харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх, харилцааг иж бүрэн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх зорилгоор хоёр талын харилцааны хүрээнд болон олон улсын салбарт идэвхтэй хамтран ажиллана."
- 2003 Хоёр З/Г-ын Хамтарсан Мэдэгдэл (Ер. Сайд Койзүми, Ерөнхийлөгч Багабанди)
 "Цаашид иж бүрэн түншлэлийг Э/З, соёл, боловсрол, иргэд харилцан зорчих зэрэг хоёр талын харилцаанд, түүнчлэн бүс нутгийн болон олон улсын хэмжээнд улам эрчимжүүлэн хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов."

Монголд үзүүлэх Э/З-гийн Хамтын Ажиллагаа

Шилжилтийн хүнд үеийг даван туулахад чиглэгдсэн тусламж
 (Яаралтай тусламжийн шинж чанар)

Ардчилал, 33ЭЗ-ийг хөгжүүлэхэд чиглэсэн тусламж

2004 Монголд Үзүүлэх Тусламжийн Хөтөлбөр

- 33ЭЗ-гийн тогтолцоо ба боловсон хүчин бэлдэхэд үзүүлэх тусламж
- Хөдөө орон нутгийг хөгжүүлэх тусламж
- Байгаль орчныг хамгаалах тусламж
- Э/З-гийг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтэц бий болгох тусламж

• Япон Улсын тусламжийн хэмжээ (тусламжийн хэлбэр ба жилээр)

нэгж : сая иен

Санхүүгийн жил	Йений Зээл	Буцалтгүй Тусламж	Техникийн ХА
1999 он	—	5,374	1,929
2000 он	6,139	6,568	1,958
2001 он	—	5,512	2,845
2002 он	—	4,060	2,737
2003 он	—	3,085	1,526
Бүгд	36,126	68,809	23,343

("ХАЕТ-ийн эмхтгэл, 2004 он", ГХЯ, ЭЗХАГ, 2005 он)

• Буцалтгүй Тусламж (ГХЯ)

- Ерөнхий Буцалтгүй Тусламж
- Хүнсний Тусламж (KR1), Бага Орлоготой Тариаланчид, Фермерүүдийг Дэмжих Тусламж (KR2)
- Төслийн бус буцалтгүй тусламж
- Өвсний Үндэс Буцалтгүй Тусламж

• Техникийн Хамтын Ажиллагаа (ЖАЙКА)
(2003 он хүртлэх нийт дүн)

Япон дахь сургалт	1,382 хүн
Япон мэргэжилтэн	496 хүн
Судалгааны баг	2,185 хүн
Японы хилийн чанад дахь сайн дурын ажилтан	184 хүн
Бусад сайн дурын ажилтан	35 хүн
Тоног төхөөрөмж нийлүүлэх	2,036.80 сая иен
Техникийн хамтын ажиллагааны төсөл	4 төсөл
Хөгжлийн судалгаа	33 төсөл

("ХАЕТ-ийн эмхтгэл, 2004 он", ГХЯ, ЭЗХАГ, 2005)

• Хөнгөлттэй Зээл (Японы Хамтын Ажиллагааны Банк /JBIC/)

"УБ хотын 4-р Цахилгаан Станцыг Сэргээн Сайжруулах Төсөл"


"Багануур Шивээ-Овоогийн Нүүрсний Уурхайг сайжруулах Төсөл"

2000 оны санхүүгийн жилээс хойш йений зээлийн төсөл хэрэгжээгүй байсан бөгөөд 2006 оны 3 сард Ерөнхий сайд Энхболд Японд айлчлах үеэр "Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээл"-ийг хэрэгжүүлэх тухай нот бичигт гарын үсэг зурсан. (2006 оны 3 сарын 28, нот бичгийн мөнгөний дүн: 2 тэрбум 981 сая иен)

УБ хотын 4-р цахилгаан станцыг сэргээн засварлах төсөл
Project for Rehabilitation of 4th Thermal Power Station



Замын Үүд дэх ачаа шилжүүлэн ачих байгууламжийг сайжруулах төсөл
Project for Improvement of the Transshipment Facilities at Zamyun Uud Station




Сансарын холбоог сайжруулах төсөл
Project for Improvement of Satellite Communications



УБ хотын нийтийн тээврийг сайжруулах төсөл
Project for Improvement of Public Transportation in Ulaanbaatar




Ерөнхий Боловсролын Сургуулиудын Барилгын Өргөтгөлийн Төсөл
Project for the Improvement of Primary Education Facilities



УБ хотын авто замыг сайжруулах төсөл
Project for Improvement of Road in Ulaanbaatar




Төмөр Замын Байгууламжийг Сэргээн Сайжруулах Төсөл
Project for Rehabilitation of Railway Facilities



Цаг уурын мэдээллийн сүлжээг сайжруулах төсөл
Project for Improvement of Meteorological Information Network



Эх Нялхсын ЭШТ-д дотоод холбооны сүлжээ нийлүүлэх
өвсний үндэс тусламжийн хөтөлбөр
Grassroot Project for Provision of Internal Communication
System to the Maternal & Child Hospital




Соёлын Харилцаа

- Соёлын Хамтын Ажиллагаа
 - Соёлын Ерөнхий Буцалтгүй Тусламж
 - 1984 оны санхүүгийн жилээс (СЖ) хойш нийт 18 төсөл (нийт дүн: 1 тэрбум 10 сая 300 мянга йен)
 - 2003 оны СЖ: Улсын Драммын Эрдмийн Театр
 - 2004 оны СЖ: ШУА, Археологийн Хүрээлэн
 - 2005 оны СЖ: Хөгжим Бүжгийн Коллеж
 - 2006 оны СЖ: Хархорины Музей Барих Төсөл
 - Соёлын Өвсний Үндэс Буцалтгүй Тусламж
 - 2005 оны СЖ: Соёлын Төв Өргөө (83,590 Ам. Доллар)

• Японд оюутан суралцуулах

Дээд боловсролын байгууллагуудын Монгол оюутны тоо



Улсаар ангилсан суралцагсдын тоо 924 хүн
10-р байр
10,000 хүн тутамд ноогдох тоо (3,55 хүн орчим)
1-р байр

Хөтөлбөр	Япон явсан он	2004	2005	2006
Их сургуулийн үндсэн оюутан		16	22	21
Техникийн коллеж		10	11	16
Мэргэжлийн сургууль		5	5	4
Судлаач оюутан		20	20	22
Япон хэл соёл судлаач оюутан		10	9	12
Багш нарын мэргэжил дээшлүүлэх оюутан		3	3	3
Залуу удирдагч хөтөлбөр		4	2	6
Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр (JDS)		20	19	20
Бүгд		88	91	104

• Соёлын харилцаа

Сумо

Монголын 35 сумоч (2006 оны 8 сарын байдлаар)

Ёкозүна Асаиёорюү

Макуноучи зиндзэны 7 бэлтгэгч



• Монгол Японы найрамдлын жил

2006 он
Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ой
2007 он
Дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ой

Япон дахь Монголын жил
← ЯМ хамтарсан кино

Иноуэ Ясуши "Бэртэ чоно"

Шибарёотаро "Монголд аялсан тэмдэглэл", тэмдэглэл

"талын

Монгол дахь Японы жил